

60

2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн
Ардчилсан Намын II дугаар
Их хурал-Үндэсний Чуулганаар
хэлэлцэж батлав.

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны сонгуульд
Ардчилсан Намаас нэр дэвшигч Мэндсайханы Энхсайханы
мөрийн хөтөлбөр**

Өнөөгийн нийгэм, улс төрийн нөхцөл байдлыг дараах байдлаар тодорхойлж байна.

Улсын Их Хурлын сонгуулиар ард түмэн нэг намын ноёрхлолыг халах, намуудыг төрд харилцан хяналттай байлгах, төрийг шударга болгохын төлөө саналаа өгсөн билээ. Сонгогчдын энэхүү захиалгыг удирдлага болгон “Зөвшилцлийн Засгийн газар” байгуулагдав.

“Зөвшилцлийн Засгийн газар” нь Монголын түүхэнд шинэ үзэгдэл бөгөөд энэ нь хосгүй боломжийг бий болгож байгаа ч багагүй хүндрэл бэрхшээлийг дагуулж байна. Засгийн газраас хөтөлбөрөө хэрэгжүүлэх, төрийг хээл хахуулиас цэвэрлэж, мэргэшсэн төрийн албыг бүрдүүлэх, өрх гэрийг “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрөөр дамжуулан дэмжих анхны алхамыг хэрэгжүүлж эхэллээ.

УИХ-д улс төрийн хүчний харилцаа тэнцвэртэй болсон нь нийгэм нэг намын дарамтаас чөлөөлөгдөх нөхцөл бий болгож, иргэд эрх ашиг, сонирхлоороо нэгдэн Иргэний нийгэм хөгжих таатай бололцоо бүрдлээ.

Ардчилсан Намаас сонгогдсон УИХ-ын гишүүд Засгийн газраа тогтвортой ажиллуулах нийгэмд зоримог өөрчлөлт хийх арга замаараа ялгаран нэг хэсэг гишүүд Ардчилсан Намын бүлэг байгуулан нөгөө хэсэг нь МАХН-ын бүлэгт нэгдэн ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд эдийн засаг өсч байгаа ч ард түмний дийлэнхийн амьдрал дорой хэвээр, ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна.

Төр, засаг ард түмний хоорондын холбоо, эрх баригчид сонгогчдын итгэлцлийг бэхжүүлэх шаардлага тулгарлаа.

Үүссэн нөхцөл байдалд Ардчилсан Намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч миний бие дараах зорилт, санаачилгыг дэвшүүлэн ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

71
61

Төрийн тэргүүний бүрэн эрхийн хүрээнд
хэрэгжүүлэх зорилт, санаачилгууд

Нэгдүгээрт, Монгол улсын Ерөнхийлөгчийн явуулж ирсэн бодлогын залгамж чанарыг хадгалан хөгжүүлж, үндэсний эв нэгдлийг дээдлэн ажиллана.

Хоёрдугаарт, УИХ-ын сонгуулийн дүнг хүндэтгэж, УИХ-д дахь намуудын тэнцвэртэй харилцааг бий болгох, УИХ-ын үйл ажиллагааг ил тод, үр дүнтэй болгоход анхаарна. Сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газрыг тогтвортой ажиллуулж, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Гуравдугаарт, Нийгмийн баялгийг шударга хуваарилаж ядуурал, ажилгүйдлийг бууруулна. "Чинээлэг дундаж давхрага" хөтөлбөр гаргана.

Дөрөвдүгээрт, Монголын төрийг улс төр-бизнесийн явцуу бүлэглэлийн дарамт, шахалтаас ангид байлгаж, намуудын хооронд ажил хэрэгч хамтын ажиллагааг дэмжинэ.

Тавдугаарт, Хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байх зарчим хэрэгжих нөхцлийг бүрдүүлж, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх цогц бодлого явуулна.

Зургаадугаарт, Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгааг хангах шинэ бодлогыг гаргаж, Зэвсэгт хүчний энхийг сахиулах чадварыг нэмэгдүүлнэ.

Долоодугаарт, Гадаадад ажиллаж, амьдарч сурч байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах чиглэлээр идэвхтэй гадаад бодлого явуулна.

Наймдугаарт, Авилгал, хээл хахуультай тууштай тэмцэж, төрийг авилгачдаас цэвэрлэх, тэдэнд хуулийн дээд цээрлэл үзүүлэх бодлого явуулна.

Есдүгээрт, Иргэдийнхээ сүсэглэх, бишрэх эрх, эрх чөлөөг хүндэтгэн, уламжлалт бурхан шашны хутагт хувилгаадыг Монголоос төрүүлдэг байсан тасалдсан уламжлалыг сэргээх бодлогыг дэмжинэ.

Аравдугаарт, Иргэд, эрдэмтэн судлаач, улс төрчдын оролцоотойгоор "Үндэсний үзэл санаа"-г 2006 онд болох Тулгар төр байгуулагдсан их ойн баяраас өмнө боловсруулж Монгол хүн бүрийн хүртээл болгоно. Энэ нь Монгол хүн бүр эх орондоо хайртай, хүн хүндээ өмөг түшэг болж, улс орноо хөгжүүлэх хүн бүрийн оюун санааны хөдөлгүүр бий болгох зорилгыг хангана.